

АГУУЛГА

Оршил	2
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн тухай товч танилцуулга.....	3
1.2. Төслийн зорилго.....	3
1.3. Уурхайн байршил.....	3
1.4. Төслийн хүчин чадал.....	5
1.5. Ордыг ашиглах технологийн сонголт	5
1.5.1. Ил уурхайн олборлолт	5
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	6
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	7
4. сӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	8
5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	12
8. ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	15
10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	16
11. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	18
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	19

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2020.09.25-ний өдрийн 13/6549 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2022 онд “Мон газар экологи” ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр “Жонш толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд энэхүү 2026 оны БОМТ нь 2022 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн 5 дахь жилийн БОМТ юм.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тухай товч танилцуулга

Төслийн нэр: “Жонш толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах”

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Экилешия” ХХК

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-014111

ААН улсын бүртгэлийн дугаар: 9011254020

Регистрийн дугаар: 5411726

Хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо,
Нарны зам, 87-305

Холбоо барих утас: 88003860

1.2. Төслийн зорилго


Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй болно. Иймд Монгол улсын Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын хууль, Байгаль хамгаалах хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, байгалийн баялгийг алдагдал хаягдалгүй бүрэн ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр уурхай, санхүүгийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж ажиллах болно.

1.3. Уурхайн байршил


Баруун Цагаан дэлийн “Жонш Толгойн” хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт оршино. Улаанбаатар хотоос зүүн урагш 320 орчим км, Дорноговь аймгийн Айраг сумаас баруун урагш 23 орчим км зайтай байрлана. Ашиглалтын MV-014111 тоот тусгай зөвшөөрөл бүхий Жоншт толгойн хайлуур жоншны ордын 1, 2, 3-р хүдрийн биетийн талбай хэмжээ 38.0 га бөгөөд дараах газар зүйн солбилцлоор хязгаарлагдана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	109	7	26.72	45	40	26.61
2	109	7	26.72	45	40	9.61
3	109	7	51.72	45	40	9.61
4	109	7	51.72	45	40	1.62
5	109	7	11.72	45	40	1.62
6	109	7	11.72	45	40	26.61



Зураг 1. Төслийн талбайн байрзүйн зураг



Зураг 2. Төслийн талбайн байршил

1.4. Төслийн хүчин чадал

Уурхайн хүчин чадал нь 2026 онд 22.0 мян.т жоншны хүдэр олборлохоор байна. Уурхай нь өвлийн улиралд улирлын зогсолт хийж 5-11 сард (жилд 172 хоног) ажиллана.

1.5. Ордыг ашиглах технологийн сонголт

Төслийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-д тусгаснаар ордын хайлуур жоншны судал нь 700 уналтай, зузаан нь дунджаар 3.92 м байна. Газрын гадаргатай ойрхон судалтай өмнө нь ил аргаар ашиглаж байсан учир авто тээвэртэй ил аргаар ашиглахад тохиромжтой байна.

1.5.1. Ил уурхайн олборлолт

Ордын хайлуур жоншны судал нь 70° уналтай, зузаан нь дунджаар 3.92 м байна. Газрын гадаргатай ойрхон судалтай өмнө нь ил аргаар ашиглаж байсан учир авто тээвэртэй ил аргаар ашиглах тохиромжтой гэж үзлээ.

Хүснэгт 2. Ашиглалтын систем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Тэсэлгээ хийх
		Ухаж ачих
		Тээвэрлэх
		Гадаад овоолго
	Хүдэр олборлолт	Тэсэлгээ хийх
		Ухаж ачих
		Тээвэрлэх

Жоншт толгойн ордын нөөцийг аль болох бүрэн ашиглах зорилгоор захиалагч талд бэлэн байгаа тоног төхөөрөмж, уурхайн орлын өргөн болон ажлын хамгийн бага талбайгаас хамааран загварчилахад 62841 тонн хүдэр олборлон, 1947.15 тонн хүдэр хүрээ хязгаараар хязгаарлагдаж байхаар төсөлд тусган байна. Жоншт толгойн 1, 2, 3-р хүдрийн биетүүдийн хайлуур жоншны ил уурхайн хил хязгаарыг нийт В зэрэглэлийн нөөцийг ашиглах хүрээнд дараах байдлаар явуулахаар тогтоов. Уурхайн дундаж гүн 29м, урт 127м, өргөн 25м бөгөөд уурхайн талбайн хэмжээ 1.35 га байхаар төлөвлөж байна.

Ил уурхайн хил хүрээг сонгохдоо ордын нөөцийг иж бүрэн ашиглах боломж, уурхайн хүчин чадал, аюулгүй ажиллагааны шаардлага, байгаль орчны нөхөн сэргээлтийн хэтийн төлөв байдал, эдийн засгийн хувьд хамгийн бага зардлаар ашиглах нөхцөл зэргүүдийг харгалзан үзлээ. Мөн II-р бүлгийн орд тул В нөөцөнд тулгуурлан нөөцийн тооцоог хийсэн байна.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уурхайн талбай нь Дорноговь аймгийн Айраг сумын 1-р багийн нутаг, Айраг сумын төвөөс баруун урагш 23 км зайд байрлана. Тус төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл тус төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

Хүснэгт 3. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
<i>Агаар орчин</i>			
1	Тоосжилт (PM _{2.5} PM ₁₀)	-Ажилчдын хөл хөдөлгөөн -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн -Гадаад, дотоод тээвэр -Үржил шимт хөрсний овоолго	-Тархах хүрээ хязгаарлагдмал -Салхины хурд бриксийн хурдаас давах, агаарын температур их үед үүснэ.
2	Хийн хаягдал (Утаа, Угаар, SO, NO, CO)	-Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгүүр	-Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
<i>Усан орчин</i>			
3	Усны нөөцийн хомсдол	-Унд ахуйн усны хэрэглээ	-Ажилчдын унд-ахуйн усны хэрэглээг Айраг сумын төвд гүний худгаас хангана.
4	Хатуу болон шингэн хаягдал	-Ахуйн хог хаягдал -Шатах тослох материалын хаягдал	-Газрын ус бохирдох бусад эх үүсвэрүүд -Газрын доорх усны бохирдолд өртөгдөх байдал -Удаан сарнина -Гадаргын хэлбэрши
<i>Хөрсөн бүрхэвч</i>			
5	Элэгдэл, эвдрэл	-Уурхайн олборлолт -Гадаад, дотоод тээвэр	-Тархалтыг хязгаарлах боломжтой -Нөхөн сэргээх боломжтой
6	Бохирдол	-Ахуйн хог хаягдал -Шингэн хаягдал -ШТМ-ын асгаралт	-Тархах хүрээ хязгаарлагдмал -Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. Хөрсний бохирдол шингээх хурд
<i>Ургамлан бүрхэвч</i>			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	-Уурхайн олборлолт -Уурхайн тээврийн зам	-Хэмжээ хязгаарлагдмал -Ургамлын төрөл зүйл устгах -Ногоон байгууламж, тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой
<i>Нийгэм-эдийн засгийн орчин</i>			
8	Ажилчид	-Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ	-Хүн амын эрүүл мэндэд эерэг нөлөө их
9	Үндсэн хөрөнгө	-Татварын эх үүсвэр	-Улсын төсөвт хувь нэмэр оруулна
10	Шинэ ажиллагсад	-Ажлын байр бий болно	-Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчин бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах үндсэн зорилготой.

Тус төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан. Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөвт 41.31 сая.төг зарцуулахаар төлөвлөсөн.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1	Тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас тоосжилт үүсэх	Усалгааны хуваарийг цаг агаарын мэдээнд үндэслэн боловсруулах	Уурхайн бүс	ҮАЗ				Дулааны улиралд 5-9 сар	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн үндсэн шаардлага
2		Тээврийн хэрэгслүүдээс үүсэх тоосжилтыг бууруулах усалгаа хийх	Уурхайн бүс, зам талбай	төг	185	7500 м ²	300.0		
3	Утаа болон хийн бохирдол үүсэх	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Төсөлд ашиглах тээврийн хэрэгслүүд	төг	19,000	8 техник	152.0	Жилд 1 удаа	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Ус ашиглах боломжит нөөцийн тооцоонд	Шүүрлийн усанд тоолуур суурьлуулах	Уурхайн ухаашаас гарах шүүрлийн ус	ш	250,000	1	250.0	Уурхайн усыг шавхан зайлуулахаас өмнө	
2	тусгагдсаны дагуу ариг гамтай ашиглах	Тоолуурын мэдээг сар бүр Айраг сумын БОАХМ-ээр баталгаажуулах	Уурхайн ухаашаас гарах шүүрлийн ус	ҮАЗ				Сар бүр	

3		Ундны усны шинжилгээг ОХШХ дагуу 2 3 4 улиралд шинжлүүлэх	Уурхайн ундны ус						
Хөрсөн бүрхэвч									
1	ШТМ газрын гадрага болон хөрсөн бүрхэвчид нөлөө үзүүлэх	Хөрсөнд шатах тослох материал алдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Төсөлд ашиглах тээврийн хэрэгслүүд	ҮАЗ				Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль,
2	Олон салаа зам гарснаар орнчы газрын гадрага хөрс ургамлан бүрхэвч устгах	Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээг засах	Дотоод болон гадаад тээврийн зам	ш	50,000	8	400.0	2-3 улиралд	
3		ШТМ-аар хөрс бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	Засварын газар, кемп, авто зогсоол	м ²	ҮАЗ		Асгаралт үүссэн тохиолдол бүрт		
Ургамлан нөмрөг									
1	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устгах	Уурхайн тээврийн зам дагуу ургамлын аймгийг тодорхойлох цэгт ургамлын мониторинг хий	Тээврийн зам	-	ҮАЗ			6-9 сарын хооронд	Ургамлын мониторинг хийх аргачлал, торон арга
НИЙТ					4,230.0 мян.төг				

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
	Ахуйн	Ахуйн хог хаягдлын цэгийн байгуулах	Төслөөс үүсч буй бүх хог хаягдал	төг	-	2	1,500.0	2-3 улиралд	Хог хаягдлын цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар
		Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг Айраг сумын ЗДТГ-тай байгуулах	Төслөөс үүсч буй ахуйн хог хаягдал	төг	-		1,500.0	1 улиралд	
		Ажилчдын кемпээс гарч буй хуванцар савыг цуглуулж, дахин боловсруулах ААН нийлүүлэх	Ажилчдаас үүсч буй хуванцар сав	ш		ҮАЗ		Жилийн турш	
	Уурхайн	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, тэмдэгжүүлэн талбай бэлдэх	Хаягдал дугуй, төмөр	төг		ҮАЗ		Жилийн турш	
		Хуримтлуулсан хог хаягдлыг дахин боловсруулдаг болон устгадаг байгууллагад нийлүүлэх				ҮАЗ			

“Экилешия” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт хэрэгжиж
 буй “Жонш толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн
 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

	Аюултай	Ашигласан тос маслыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Төслөөс үүсэх ашигласан тос масло	төг	ҮАЗ	Жилийн турш	
		Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авах	Төслөөс үүсч буй аюултай хог хаягдал		ҮАЗ	ДГА, БОГ-аас авна	
Нийт				3,000.0 мян.төг			

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ								
№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн техникийн нөхөн сэргээлтийг дотоод овоолгоор хийх	га	3,3		30,000,000	2026	Техникийн нөхөн сэргээлт хийх аргачлал
Нийт				21,000.0 мян.төг				

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ							
№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	3	4	5	6	7	8
1	Орон нутгаас санал болгосны дагуу шувууны үүр хийх	төг			5,000.0	2026	
Нийт			5,000.0 мян.төг				

8. ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Уурхайн үйл ажиллагааны явц дахь гэнтийн осол	Анхны тусламжийн иж бүрдэл хүрэлцээтэй хэмжээгээр бэлтгэх	Уурхайн ажилчдад	1	100.0		Тогтмол	-
2		ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулах	Уурхайн ажилчдад	ХАБЭА төлөвлөгөөний дагуу		Тогтмол		
3		Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Уурхайн ажилчдад	ХАБЭА төлөвлөгөөний дагуу		Тогтмол		
4		Уурхайн тэмдэг тэмдэглэгээг хэрэгцээт хэмжээгээр байрлуулах	Уурхайн бүс	ҮАЗ		2026 он		
1	Болзошгүй гал түймэр	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын дохиолол, хүрз, элс, хөөс, аюулгүй байдлын самбар) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулаж, дууссан тохиолдолд цэнэглүүлэх	Уурхайн бүс	800,000		Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль	
1	Болзошгүй үерийн аюул	Гамшиг, аюул ослын үед ажиллах төлөвлөгөө гаргах	Уурхайн ажилчдад	ХАБЭА төлөвлөгөөний дагуу		Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль	

“Эжилешия” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт хэрэгжиж
буй “Жонш толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн
2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

2	болон газар хөдлөх						
	Нийт				1,180.0 мян.төг		

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР									
№	Байгаль орчны хүчин зүйл	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		1	2	3	4	5	6	7	8
1	Агаарын сорьц шинжилгээ	NO2 S02	Кемп Ухаш Овоолго	Жилд 2 удаа	3 цэгт 2 удаа	25.0	150.0	Уурхайн үйл ажиллагаа хэвийн явж байх үед дээжлэлт хийнэ	Дээжлэхдээ MNS 4585:2007, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
2		Тоос (нийт, PM10, PM2.5)	Кемп Тээврийн зам Овоолго орчим Ухаш		4 цэгт 2 удаа	10.0	80.0		
	Хөрсний шинжилгээ	Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж: рН,, чийгшил, ялзмаг, NH4, NO3, SO4, P2O5	Харьцуулах хөрс Уурхайн суурин Шимт хөрсний овоолго	Жилд 2 удаа	3 цэгт 2 удаа	25.0	150.0		MNS3298-90 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
		Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж	Авто зогсоол Засварын газар Тээврийн зам дагуу		3 цэгт 2 удаа	35.0	210.0		MNS5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

“Экилешия” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт хэрэгжиж буй “Жонш толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

		Усны чанар: Өрөнхий химийн шинжилгээ	Ундны ус Шүүрлийн ус	2 3 4 уилралд	2 цэгт 6 удаа	40.0	320.0		MNS (ISO) 5667-5:2001- усны чанар-дээжлэлт
	Усны шинжилгээ	Бохир ус: рН, Ж/б, ХХХ, БХХ, NH4, NO2, NO3, N-нийт, Р-эрд	Ахуйн бохир ус	Жилд 2 удаа	1 цэгт 2 удаа	65.0	130.0		MNS (ISO) 5667-10:2001 “Усны чанар, дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
		Дуу шуугиан	Тайван байх үед Тоног төхөөрөмж ажиллаж байх үед Тээврийн зам дагуу	Жилд 1 удаа	3 цэгт 1 удаа	30.0	90.0		
	Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн	Ургамлын мониторинг	Уурхайн ургамлыг тодорхойлох 1 цэгт Тээврийн зам дагуу	Жилд 1 удаа	ҮАЗ				
Нийт					1,200.0 мян.төг				
10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ									
№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2026 он						
			Сар 1-3	Сар 4-7	Сар 8-12				

“Экилешия” ХХК-ний Дорноговь аймгийн Айраг сумын нутагт хэрэгжиж
буй “Жонш толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн
2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026

	1	2	3	4	5	6	7
2	Газар, автын, хог хаягдлын төлбөр төлөх	5,000.0			X	Нягтлан	
3	Ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	500.0	X			Хүний нөөцийн мэргэжилтэн	
4	Төлөвлөгөөт газрын хянан баталгаа хийлгэх	ҮАЗ	X			БОМ	
	Нийт	5,500.0					

11. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ							
№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
	Засаг дарга, сумын байгаль орчны байцаагч	Бичгэн тайлан	БОМТ биелэлт	2026.11.1-15	200.0	БО мэргэжилтэн	
	Төрийн захиргааны төв байгууллага	Цахим	БОМТ биелэлт	2026.11.1		БО мэргэжилтэн	
	Нийт				200.0		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	Зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	4,230,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,000,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,180,000
4	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21,000,000
5	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,000,000
6	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Түүх соелын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,200,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	5,500,000
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200,000
Нийт		41,310,000 төг